

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2020.01.13 - 01.17

Ти Ди Би Капитал ҮЦК нь Монголын хөрөнгийн биржтэй шууд холбогдсон арилжааны системийг ашиглан үнэт цаасны арилжаанд хамгийн түргэн шуурхай оролцох боломжийг олгож байна.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: АНУ болон БНХАУ хоорондын эхний шатны худалдааны хэлэлцээр батлагдсанаас гадна эдийн засгийн үзүүлэлтүүд эерэг байгаатай холбоотой энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд түүхэн дээд хэмжээнд хүрлээ.

Зах зээлийн үнэлгээ багатай индексүүд хөрөнгийн зах зээлд өсөлтөөрөө тэргүүлсэн ба ус, цахилгаан болон дулааны хангамжийн салбарын компаниудын хувьцаа хамгийн их өсөлттэй байсан бол эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа бууралттай байлаа.

Лхагва гарагт Цагаан ордонд худалдааны хэлэлцээрийг батлах ёслол болсон ба үүнтэй зэрэгцээд худалдааны хэлэлцээртэй холбоотой нарийн мэдээллүүд ил болсон юм. Эдгээрээс АНУ-ын хөрөнгө оруулагчдын анхаарлыг хамгийн их татсан мэдээлэл нь БНХАУ-аас 2021 он гэхэд 200 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний бүтээгдэхүүнүүдийг АНУ-аас худалдан авна хэмээх амлалт байсан ба зарим хөрөнгө оруулагчид БНХАУ энэхүү амлалтаа биелүүлж чадна гэдэгт эргэлзэж байгаа юм. Харин АНУ-аас энэхүү хэлэлцээрийн хүрээнд зарим бараа бүтээгдэхүүний гаалийн татварыг 15%-аас 7.5% болгон бууруулсан ч БНХАУ-ын 250 тэрбум ам.долларын бүтээгдэхүүнүүдэд ногдуулсан 25%-ийн гаалийн татвар хэвээр байгаа юм.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд худалдааны маргааны асуудал эерэгээр шийдэгдэж байгаа болон БНХАУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүд эерэг байгаатай холбоотой өсөлттэй байлаа.

Их Британи улсын эдийн засгийн сул үзүүлэлтүүд болон Английн төв банкны Мөнгөний бодлогын хорооны гишүүдийн мэдэгдлүүдээс үүдэн хөрөнгө оруулагчид 1-р сарын 30-ны мөнгөний бодлогын хорооны ээлжит хурлаар бодлогын хүүг бууруулна хэмээн таамаглаж байна. Сүүлийн 3 сарын своп хэлэлцээрийн ханшийн мэдээлэлд үндэслэхэд бодлогын хүүг 0.75%-аас 0.50% болгон 0.25%-аар бууруулах магадлал 80%-тай байгаа юм.

ХБНГУ-ын Статистикийн газрын урьдчилсан таамгаар ХБНГУ-ын эдийн засаг 2019 онд 0.6%-аар өссөн байна. Энэхүү үзүүлэлт нь 2013 оноос хойших хамгийн бага үзүүлэлт ба сүүлийн 10 жилийн эдийн засгийн дундаж өсөлт болох 1.3%-аас бага байгаа юм. 2019 оны өсөлтийн ихэнх хувийг хэрэглээний зардал болон барилга угсралтын салбарын цэвэр үндсэн хөрөнгийн зардал эзэлж байгаа юм.

Япон: 2020 оны 1-р сарын 13-ны Даваа гарагт Япон улсын хөрөнгийн зах зээл хаалттай байсантай холбоотой арилжааны хэмжээ бага байсан энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн зарим индексүүд өсөлттэй байсан бол зарим индексүүд уналттай байлаа.

Япон улсын Төв банкнаас хойд Хокурику, төв Токай болон баруун Чугоку бүс нутгуудын эдийн засгийн үнэлгээг экспортын хэмжээ буурсантай холбоотой бууруулсан байна.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоног эхлэхэд бага зэргийн өсөлттэй байсан ба худалдааны хэлэлцээртэй холбоотой том хэмжээний өсөлт үзүүлээгүй байна. БНХАУ-ын хөрөнгө оруулагчид энэхүү хэлэлцээр нь АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой түр арга хэмжээ гэж үзэж байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,100.15	-0.77% ▼
Dow Jones	АНУ	29,348.10	1.82% ▲
S&P 500	АНУ	3,329.62	1.97% ▲
Nasdaq	АНУ	9,388.94	2.29% ▲
S&P/TSX	Канад	17,559.02	1.88% ▲
FTSE 100	Их Британи	7,674.56	1.14% ▲
S&P/ASX 200	Австрали	7,064.10	1.95% ▲
Nikkei 225	Япон	24,041.26	0.80% ▲
Hang Seng	Хонг Конг	28,883.04	0.85% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	114.72
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.66
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.55
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	108.77
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.12
DBM' 2023	USD	7.250%	107.45
TDBM' 2020	USD	9.375%	101.61
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	98.47

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.654	-0.02 ▼
Libor 3M	1.819	-0.02 ▼
Libor 6M	1.845	-0.03 ▼
Libor 1YR	1.923	-0.04 ▼
US 2YR Bond	1.559	-0.01 ▼
US 3YR Bond	1.567	-0.02 ▼
US 5YR Bond	1.620	-0.01 ▼
US 10YR Bond	1.822	0.00 ▲

Валютын ханш	2020.01.17	Өөрчлөлт
USD	2,746.22	0.27% ▲
CNY	400.42	1.34% ▲
EUR	3,058.33	0.53% ▲
RUB	44.67	0.02% ▲
KRW	2.37	0.42% ▲
JPY	24.92	-0.32% ▼
CAD	2,106.97	0.47% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,557.24	-0.33% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	18.04	-0.41% ▼
Зэс	USD/lb.	284.55	1.14% ▲
Нүүрс	USD/MT	70.68	-4.64% ▼
WTI газрын тос	USD/bbl.	58.54	-0.85% ▼
Brent газрын тос	USD/bbl.	64.85	-0.20% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. XI	5.2%
Бодлогын хүү	2019. XI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. XI	11.20%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. XI	11.49%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. XI	4.80%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. XI	16.88%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. XI	10.58%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 51 компанийн 545.5 сая төгрөгийн 6,718,763 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Адуун чулуун” /ADL/, “Монгол даатгал” /CHE/ болон “Фронттиер лэнд групп” /MDR/ компаниудын хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,357.0 төгрөг, 80.50 төрөг болон 389.85 төгрөг хүрч хаагдсан бол “Дархан нэхий” /NEH/ компанийн хувьцаа 14.09%-аар буурч 12,010.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


01-р сарын 17-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,664.1 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,100.15 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.77%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2020 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн тойм

Арилжигдсан үнийн дүн	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	545.5
Зах зээлийн үнэлгээ	2,664,137.1

Зах зээлийн индексүүд

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,100.15	-0.77% ▼
MSE I индекс	9,356.59	-0.84% ▼
MSE II индекс	7,797.74	0.22% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн
Лэндмн ББСБ	5,750,982	266,219,309
Ард санхүүгийн нэгдэл	39,382	64,655,752
Инвексдор ББСБ	13,448	35,197,902
Монос хүнс	307,502	21,420,946
Түмэн шувуут	125,397	18,875,432

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт	Өөрчлөлт
Адуун чулуун	1,357.00	15.00% ▲
Монгол даатгал	80.50	15.00% ▲
Фронттиер лэнд групп	389.85	15.00% ▲
Сор	1,150.00	15.00% ▲
Тав	20,100.00	14.86% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт	Өөрчлөлт
Дархан нэхий	12,010.00	-14.09% ▼
Женко тур бюро	69.00	-13.75% ▼
Дархан гурил тэжээл	4,879.00	-12.88% ▼
Тээвэр дархан	7,800.00	-9.57% ▼
Хөвсгөл алтан дуулга	650.00	-6.74% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК

ҮЦК	Дүн (төг)
Мирэ Өссет Секюритиз Монгол	522,061,809
Ард Секюритиз	137,784,955
Голомт Капитал	80,007,517
Би Ди Сек	51,507,208
Ти Ди Би Капитал	45,658,721

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	614.66	654,110
Таван толгой	6,495.00	342,060
МИК Холдинг	15,000.00	310,640
Говь	260.06	202,876
Инвексдор ББСБ	2,652.00	190,222

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ




ОНЦЛОХ МЭДЭЭ

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр сургалт зохион байгууллаа.
- Хороо Дэлхийн банктай хамтран ажиллаж байна
- Хорооны 2020 нэгдүгээр хуралдаан болов.
- Хөрөнгө оруулалтын 2 санг нэмж бүртгэв.
- “Компанийн бондын зах зээлийн хөгжил болон зохицуулалтын орчин” сэдэвт хэлэлцүүлэг боллоо.

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

- Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Төсөв санхүүгийн тогтвортой байдлын бэхжүүлэх төсөл”-ийн бүрэлдэхүүн хариуцсан ахлагч Үлле Лохмус болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан мэргэжилтэн Стуард Икона нарыг хүлээн авч, хамтын ажиллагааны талаар ярилцав.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 1-р хуралдаан болж 17 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.
- “Баян алдар ББСБ” ХК-ийн үнэт цаасны арилжааг зогсоолоо.
- “Монгол даатгал” ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээлээ.
- “Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК эцсийн ТЭЗҮ болон анхан шатны инженерийн загварчлалын ажлуудыг эхлүүлээ.
- “Инвескор ББСБ” ХК нь Киргизийн компанид хөрөнгө орууллаа.



ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

Монголбанк Төв банкны 7 хоногийн хугацаатай үнэт цаасны хүүг 2007 оны 7-р сараас бодлогын хүү болгон зарласан ба бодлогын хүүг хамгийн сүүлд 2018 оны 11-р сарын 28-ны өдөр шинэчлэн 11% болгосон билээ.

Монголбанкны бодлогын хүү хөдлөхөд түүнийг дагаад арилжааны банкуудын хадгаламжийн хүү, улмаар зээлийн хүүнд өөрчлөлт орохоор хүлээгддэг. Монголбанкны бодлогын хүүний өөрчлөлт нь Төв банкнаас баримталж буй мөнгөний бодлого аль чиглэлд /хатуурах, зөөлрөх/ өөрчлөгдөж буйг илтгэхийн сацуу банк хоорондын захын хөтөч хүүний үүргийг гүйцэтгэнэ.

2019 оны 12-р сарын 20-ны Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны ээлжит хурлаар эдийн засгийн өсөлт болон зээл олголт саарч буйтай холбоотой бодлогын хүүг бууруулах хувилбарыг хэлэлцсэн ч төсвийн гүйцэтгэл, гадаад орчны тодорхой бус байдлыг харгалзан үзэж бодлогын хүүг 11%-д хэвээр хадгалсан.

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

- Дэлхийн банкны дэд ерөнхийлөгч Монголд айлчлав.
- Дэлхийн банкны хаврын уулзалтаар “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн үр дүнг хэлэлцэнэ
- TRQ: 2020 онд “Оюу Толгой” төслийн далд уурхайд 1.2-1.3 тэрбум ам.долларын хөөрөнгө зарцуулна.
- 2019 оны сүүлийн саруудад инфляц саарч, төсөв алдагдалтай гарлаа.
- ҮСХ: Монгол улсын далд эдийн засаг ДНБ-ий 9.2-15.7 хувьд хэлбэлзэж байна.
- Төв банк “Эрдэнэт үйлдвэр”, “Оюу Толгой”-гоос валют худалдан авч нөөцөө нэмж байна.



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

- Төв банк 2016 онд 18.6 тн, 2017 онд 20 тн, 2018 онд 22 тн, 2019 онд 15.1 тн үнэт металл худалдан авч нөөцөө нэмэгдүүлсэн байдаг. Өнгөрсөн оны тухайд эрх зүйн орчинтой холбогдуулан алт худалдан авалт буурсан юм. Тиймээс Төв банк үнэт металл худалдан авахаас гадна томоохон экспортлогч компаниудтай хэлцэл хийх замаар гадаад валют худалдан авч, гадаад валютын нөөцийг арвижуулсан байна.
- Монгол Улсыг ФАТФ-ын “саарал жагсаалт”-д орсон талаар өнгөрсөн оны 10-р сарын 18-нд албан ёсоор зарласан. Үүнтэй холбогдуулан Төв банкнаас энэ онд багтан ФАТФ-ын “саарал жагсаалт”-аас гарах зорилт тавьсан талаараа танилцуулсан. Тэгвэл Үр дүнтэй байдлын тайланг хэлэлцэх Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн хурал жилд гурван удаа болдог ба эхний хурал энэ сард болох юм. Монгол Улсын хувьд энэ хурлаар тайлангаа хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

2019 онд Монгол Улс нийт 36.4 сая тонн чулуун нүүрсийг 3.07 тэрбум ам.доллароор экспортолсон талаар Гаалийн ерөнхий газар мэдээллээ.

Үүний дийлэнх хэсэг буюу 98 хувийг БНХАУ-д, үлдсэн багахан хэсгийг Их Британи болон Сингапурт гаргажээ. Боомтоор нь задлаад харвал Тавантолгойн бүлэг ордын нүүрсийг гаргаж байгаа Гашуунсухайт боомтоор 20.6 сая тонн нүүрс гаргасан байна.



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.